

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/12/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273465 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.16 № 01/53
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ж.ОТГОНЧУЛУУН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь тайлант онд жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх судалгаа болон 10 жил дутам болдог хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг явуулсан байна. Нийслэл, аймгийн ажил дүгнэх журам, Үндэсний Статистикийн хорооны хөдөлмөрийн дотоод журам, статистикийн улсын байцаагчийн дүрэм, статистикийн бүтээгдэхүүн бэлтгэх заавар, эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам, статистик байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, статистикийн байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгүүд тус тус 2022 онд шинэчлэгдэн хэрэгжиж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ-АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,134,309.00	2,866,609.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,134,309.00	2,866,609.00
35400	Хангамжийн материал	6,134,309.00	2,866,609.00
35410	Бичиг хэргийн материал	4,691,900.00	954,900.00
35420	Аж ахуйн материал	584,909.00	612,409.00
35440	Түлш, шатах тослох материал	620,000.00	890,000.00
35470	Бусад хангамжийн материал	237,500.00	409,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	42,096,348.37	139,713,835.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	42,096,348.37	139,713,835.89
39200	Биет хөрөнгө	42,096,348.37	139,713,835.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,375,000.00	109,375,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,375,000.00	-33,375,000.02
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	68,290,805.09	96,105,791.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,649,176.60	-32,782,195.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,714,493.00	5,714,493.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,259,773.12	-5,324,253.14
39301	Програм хангамж	520,000.00	520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-520,000.00	-520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	48,230,657.37	142,580,444.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	48,230,657.37	142,580,444.89
51	Засгийн газрын хувь оролцоо	48,230,657.37	142,580,444.89
51200	Хуримтлагдсан үр дүн	48,230,657.37	142,580,444.89
51210	Өмнөх үеийн үр дүн	49,484,909.96	48,230,657.37
51220	Тайлант үеийн үр дүн	-1,254,252.59	94,349,787.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	48,230,657.37	142,580,444.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	251,046,618.00	499,148,705.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,661,200.00	108,551,786.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,661,200.00	108,551,786.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,551,200.00	107,814,986.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,551,200.00	107,814,986.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	110,000.00	736,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	240,385,418.00	390,596,919.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	115,396,100.00	116,987,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	115,396,100.00	116,987,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124,989,318.00	273,609,219.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,989,318.00	273,609,219.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	252,300,870.59	404,798,917.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,300,870.59	404,798,917.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	249,087,707.39	384,386,109.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,658,647.80	143,251,793.50
210101	Үндсэн цалин	97,143,684.83	117,389,923.50
210102	Нэмэгдэл	22,643,402.22	17,612,402.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,365,209.35	3,558,000.00
210104	Урамшуулал	6,506,351.40	4,691,468.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,307,478.00	17,734,723.50
210201	Тэтгэврийн даатгал	11,593,168.00	12,780,378.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,307,325.00	1,355,346.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,045,857.00	1,067,477.22
210204	Ажилгүйдлийн даатгал	207,415.00	230,138.24
210205	Эрүүл мэндийн даатгал	2,153,713.00	2,301,384.04
2104	Хангамж, бараа материалын зардал	25,608,192.00	38,757,910.00
210401	Бичиг хэрэг	5,176,490.00	4,687,100.00

210402	Тээвэр, шатахуун	19,745,000.00	32,740,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	503,482.00	988,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	77,000.00	342,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	106,220.00	0
2107	Томилолт, зочны зардал	17,861,000.00	31,973,000.00
210702	Дотоод албан томилолт	17,861,000.00	31,973,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,070,477.00	142,471,184.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,867,397.00	142,251,304.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,000.00	70,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,280.00	134,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	14,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,581,912.59	10,197,498.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,224,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,357,912.59	10,197,498.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,213,163.20	20,412,808.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	176,400.00	196,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	176,400.00	196,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,036,763.20	20,216,008.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	807,137.72	16,370,508.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,229,625.48	3,845,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,254,252.59	94,349,787.52
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,254,252.59	94,349,787.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	256,803,418.00	390,596,919.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	256,803,418.00	390,596,919.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	115,396,100.00	116,987,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	115,396,100.00	116,987,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,407,318.00	273,609,219.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,989,318.00	273,609,219.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,418,000.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	243,934,018.00	390,596,919.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	243,934,018.00	390,596,919.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,701,254.80	370,184,111.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	123,915,403.07	143,086,227.00
210101	Үндсэн цалин	90,400,440.10	117,224,357.00
210102	Нэмэгдэл	22,643,402.22	17,612,402.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,365,209.35	3,558,000.00
210104	Урамшуулал	6,506,351.40	4,691,468.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,583,785.73	17,734,724.00
210201	Тэтгэврийн даатгал	11,753,809.32	12,780,378.00
210202	Тэтгэмжийн даатгал	957,394.12	1,355,346.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	766,035.33	1,067,477.24
210204	Ажилгүйдлийн даатгал	191,458.79	230,138.24
210205	Эрүүл мэндийн даатгал	1,915,088.17	2,301,384.04
2104	Хангамж, бараа материалын зардал	20,102,672.00	33,043,310.00
210401	Бичиг хэрэг	514,300.00	270,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,620,000.00	31,340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	528,482.00	1,063,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	439,890.00	370,100.00

2107	Томилолт, зочны зардал	17,808,000.00	31,496,000.00
210702	Дотоод албан томилолт	17,808,000.00	31,496,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,763,894.00	144,568,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,246,964.00	143,599,870.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,000.00	70,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,280.00	134,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	14,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,313,850.00	425,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,527,500.00	255,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,527,500.00	255,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,232,763.20	20,412,808.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,000.00	196,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,000.00	196,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,036,763.20	20,216,008.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	807,137.72	16,370,508.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,229,625.48	3,845,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,869,400.00	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	12,869,400.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,869,400.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	12,869,400.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,869,400.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-12,869,400.00	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	49,484,909.96	49,484,909.96
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	49,484,909.96	49,484,909.96
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-1,254,252.59	-1,254,252.59
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	48,230,657.37	48,230,657.37
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	48,230,657.37	48,230,657.37
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	48,230,657.37	48,230,657.37
19	Тайлант үеийн үр дүн	0	0	94,349,787.52	94,349,787.52
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	142,580,444.89	142,580,444.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,987,700.00	100,617,192.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,987,700.00	100,617,192.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,790,900.00	100,420,392.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,006,500.00	87,215,228.00
210101	Үндсэн цалин	69,514,400.00	61,353,358.00
210102	Нэмэгдэл	20,992,800.00	17,612,402.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,342,400.00	3,558,000.00
210104	Урамшуулал	5,156,900.00	4,691,468.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,625,900.00	11,277,874.00
210201	Тэтгэврийн даатгал	8,585,600.00	7,758,327.50
210202	Тэтгэмжийн даатгал	1,010,100.00	892,486.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	808,100.00	700,549.24
210204	Ажилгүйдлийн даатгал	202,000.00	175,137.24
210205	Эрүүл мэндийн даатгал	2,020,100.00	1,751,373.54
2104	Хангамж, бараа материалын зардал	1,765,200.00	1,128,310.00
210401	Бичиг хэрэг	216,100.00	200,000.00
210402	Тээвэр, шатахуун	675,600.00	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	503,100.00	558,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	370,400.00	370,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,138,200.00	543,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,100.00	0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,800.00	70,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,000.00	134,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	14,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	575,500.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,100.00	255,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	255,100.00	255,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,800.00	196,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.00	196,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.00	196,800.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	116,987,700.00	100,617,192.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116,987,700.00	100,617,192.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	116,987,700.00	100,617,192.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	15	15
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	7
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	7	7
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	273,609,219.00	269,763,719.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	273,609,219.00	269,763,719.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,609,219.00	269,763,719.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,870,969.00	55,870,999.00
210101	Үндсэн цалин	55,870,969.00	55,870,999.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,925,656.00	6,456,850.00
210201	Тэтгэврийн даатгал	6,925,656.00	5,022,050.50
210202	Тэтгэмжийн даатгал		462,860.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		366,928.00
210204	Ажилгүйдлийн даатгал		55,001.00
210205	Эрүүл мэндийн даатгал		550,010.50
2104	Хангамж, бараа материалын зардал	31,959,719.00	31,915,000.00
210401	Бичиг хэрэг	79,000.00	70,000.00
210402	Тээвэр, шатахуун	31,375,719.00	31,340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	505,000.00	505,000.00
2107	Томилолт, зочны зардал	31,921,000.00	31,496,000.00
210702	Дотоод албан томилолт	31,921,000.00	31,496,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,931,875.00	144,024,870.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	145,446,875.00	143,599,870.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,485,000.00	425,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		3,845,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	273,609,219.00	273,609,219.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	273,609,219.00	273,609,219.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	273,609,219.00	273,609,219.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэхэд орших чиг үүрэг бүхий Үндэсний Статистикийн хорооны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 14 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 90,56%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс, сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан, багийн Засаг гэсэн бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд хэлтсийн дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 3, үйлчилгээний ажилтан 2, гэрээтээр 3 бүгд 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Статистикийн тухай хууль

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дотоод хяналтын багийн дотоод журам болон орон тоог Үндэсний Статистикийн хорооны даргын 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн "Эрсдэлийн зөвлөл болон орон тооны бус нэгжийн бүрэлдэхүүнийг батлах тухай" А/26 тушаалаар шинэчлэн баталж, 3 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дотоод хяналт шалгалтын хороо нь тайлант онд статистик мэдээ үйл ажиллагаанд улирал бүр, санхүү, шилэн дансанд хагас, бүтэн жилээр төлөвлөн хянаж дүгнэлт гарган хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэст тайлант онд Үндэсний Статистикийн хорооны Дотоод аудит эрсдэлийн удирдлагын газраас шилэн дансанд 2 удаа, санхүүгийн баримтад 1 удаа шалгалт хийсэн байна. Үндэсний Статистикийн хорооны даргын харьяа төсвийн шууд захирагчдын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийтлэг алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах хууль, тогтоомж, заавар, журмыг үндэслэн зөвлөмж боловсруулан ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын баг нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн Үндэсний Статистикийн хорооны даргын А/162 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 94,349.8 мянган төгрөгөөр буюу 3 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	6,134.3	2,866.6	-3,267.7
Үндсэн хөрөнгө	42,096.3	139,713.8	97,617.5
Нийт хөрөнгө	48,230.7	142,580.5	94,349.8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	48,230.7	142,580.5	94,349.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	48,230.7	142,580.5	94,349.8

Дээрх хүснэгтээс харахад Үндсэн хөрөнгийн дансанд орлого, зарлагын хөдөлгөөн хийгдсэн болон хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан өмнөх оны үзүүлэлтээс 97,617.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 142,580.5 мянган төгрөг болж 94,349.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 138,854.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсээс дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 21,866.5 мянган төгрөгөөр бууруулан Үндэсний Статистикийн хорооноос урсгал зардлын төсвийг 116,987.7 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд батлагдсан төсөвт 1 удаа тодотгол, өөрчлөлт ороогүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 /албан ёсны статистик/ хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 116,987.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 16,370.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 100,617.2 мянган төгрөг буюу 86 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 16,370.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70405 албан ёсны статистик 80101 үндсэн үйл ажиллагааны зардал	116,773.8	100,420.4	16,353.4	86
2	70405 албан ёсны статистик 80215 эрдэм шинжилгээ, судалгааны ажил	17.1	0	17.1	0
3	70405 албан ёсны статистик 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	196.8	196.8	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 273,609.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар бичиг хэрэг, шатахуунд 31,410.0 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардалд 242,199.2 мянган төгрөг нийт 273,609.2 мянган төгрөг зарцуулж, 3,845.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70405	2022.01.01-2022.12.31	Албан ёсны статистик	Хөтөлбөр 86 %	116,987.7	100,617.2

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 20,216.0 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Үндэсний Статистикийн хорооны 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан 2022 оны нийт зарлага 116,987.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 1,754.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,316.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 28 орлогын, 2 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад алдаа, зөрчил илрээгүй тул асуудлын бүртгэл хөтлөөгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	12,869.4	1	12,869.4	100
Нийт дүн	1	12,869.4	1	12,869.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.3 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант онд шатахууны 890.0 мянган төгрөгийн талон авч нөөцөлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх,” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны талон авч нөөцөлсөн	1	890.0			1	890.0						
Дүн	1	890.0			1	890.0						